

## 47 ДАХИН ТӨРСНИЙ ДАРАА

### 47.1 ЖИНХЭНЭ БАЙДАЛ

#### 47.1.1 Шинэ бүтээл

<sup>11</sup>Би өөрийнхөө гараар ямаршуу том үсгээр та нарт бичиж байгааг минь үз. <sup>12</sup>Махан бие дотроо сайхан харагдахыг хүсдэг хүмүүс Христийн загалмайн төлөө хавчигдахгүй байхын тулд та нарыг хөвч хөндөх ёслол үйлд хэмээн албадаж байгаа юм. <sup>13</sup>Учир нь хөвч хөндүүлсэн тэдгээр хүмүүс өөрсдөө хуулийг үл сахидаг. Харин тэд та нарын махан биеэр сайрхахын тулд та нарыг хөвч хөндөх ёслол үйлд хэмээн хүсдэг аж. <sup>14</sup>Харин бидний Эзэн Есүс Христийн загалмайгаар сайрхахаас өөр нь надад бүү байг. Түүгээр дамжуулан надад ертөнц, би ертөнцөд цовдлогдсон юм. <sup>15</sup>Учир нь хөвч хөндөх ба хөвч хөндүүлэхгүйн аль аль нь юу ч биш, харин шинэ бүтээл нь л чухал юм. ( Галат 6:11-15 АБ 2004)

[ ] Амьдралдаа зөв шударгыг та олж авсан уу ?

[ ] Та шинэ амьдралаараа бахархдаг уу ?

[ ] Таны амьдралд загалмайн ором, алдар суу байдаг уу ?

#### 47.1.2 Ертөнцөөс тусгаар

Итгэгчид буюу Сүнснээс төрсөн Бурханы хүүхдүүд нь ертөнцөөс тусгаарлагдсан байдаг. Хэрэв та дэлхийгээс тусгаарлагдаагүй бол таны эцсийн хүрэх газар нь там байх юм. Бурхан бол харагдах байдал эсвэл хүний бүтээсэн зүйлсийг сонирхдоггүй, харин хүний зүрхийг хайдаг.

Үйлдсэн нүглээсээ болж уйлж, гашуудаж буй зүрхийг Бурхан хайдаг. Бурхан энэрэнгүй, уурлахдаа удаан байдаг. Ялалтаар дамжуулан шударга ёсыг тогтоох хүртлээ тэрээр гэмтсэн хулсыг ч хугалахгүй буюу бүүдгэр зулыг ч бөхөөхгүй . Тэднийг наманчилж, буцаж ирэхийг Бурхан хүлээж байна.

<sup>13</sup>Ард түмнүүд галын төлөө нөр их хөдөлмөрлөн, үндэстнүүд хоосон зүйлийн төлөө эцэж ядрах нь үнэндээ түмэн цэргийн ЭЗЭНээс болж байгаа бус уу? ( Хабаккук 2:13 АБ 2004 )

Бүх үйлс нь хүлээгдэж буй шүүлт болох галд шатаагдахын тулд байдаг.

<sup>1</sup>Бузар үйлийн эсрэг ирэх шийтгэл нь тэр дороо ирдэггүй учраас тэдний дунд буй хүмүүний хөвгүүдийн зүрх нь бузар мууг үйлдэхдээ бэлэн байдаг аж. <sup>12</sup>Хэдийгээр нүгэлтэн зуу зуун удаа бузар мууг үйлдэж, амьдрал нь уртассаар байх авч, Бурханаас эмээгч тэр нэгэн, Түүний өмнө нээлттэйгээр хандагч нэгэн нь илүү дээр юм гэдгийг би мэдэв. <sup>13</sup>Гэмт хүн Бурханаас эмээдэггүй учраас түүнд сайн юм үгүй, түүний өдрүүд нь сүүдэр адил уртсахгүй. ( Номлогчийн үгс 8:11-13 АБ 2004)

#### **47.1.3 Гэм нүгэл ба хуулиас чөлөөлөгдөх**

<sup>32</sup>Тэгээд та нар үнэнийг ойлгож, үнэн та нарыг чөлөөлнө гэсэнд (Иохан 8:32 АБ 2004 )

<sup>14</sup>Үг нь махан бие болж бидний дунд оршин, бид Түүний алдрыг харцгаасан. Энэ нь Эцэгийн цорын ганц Хүүгийн алдар бөгөөд нигүүлсэл ба үнэнээр дүүрэн байсан юм. (Иохан 1:14 АБ 2004 )

<sup>17</sup>Яагаад гэвэл Хууль Мосегээр өгөгдсөн бол, нигүүлсэл ба үнэн нь Есүс Христээр дамжуулан ирсэн билээ .(Иохан 1:17 АБ 2004 )

<sup>36</sup>Иймээс хэрэв Хүү та нарыг чөлөөлбөл та нар үнэхээр эрх чөлөөтэй болно. (Иохан 8:36 АБ 2004 )

<sup>18</sup>нүглээс чөлөөлөгдөн зөвт байдлын боолууд болсон. (Иохан 6:18 АБ 2004 )

<sup>22</sup>Харин одоо нүглээс чөлөөлөгдсөн бөгөөд Бурханд боолчлогдсон та нарт ариусгалд хүрэх үр жимс авдаг.Төгсгөл нь мөнх амь болой. (Ром 6:22 АБ 2004 )

<sup>2</sup>Учир нь Христ Есүс доторх амийн Сүнсний хууль нь чамайг нүглийн болон үхлийн хуулиас чөлөөлсөн ажээ. (Ром 8:2 АБ 2004 )

<sup>22</sup>Учир нь боол байхдаа Эзэн дотор дуудагдсан хүн Эзэний чөлөөлсөн хүн мөн. Үүнтэй адил чөлөөтэй байхдаа дуудагдсан хүн Христийн боол мөн. (1 Коринт 7:22 АБ 2004 )

<sup>17</sup>Эзэн бол Сүнс мөн. Эзэний Сүнс хаана байна, тэнд эрх чөлөө байдаг. (2 Коринт 3:17 АБ 2004 )

<sup>1</sup>Христ биднийг эрх чөлөөтэй болгохын тулд чөлөөлсөн юм. Иймд бат зогс, дахиж боолчлолын буулганд бүү орогтун. (Галат 5:1 АБ 2004 )

[ ] Та тэрхүү үнэнийг олсон уу?

[ ] Та гэм нүглээсээ ангижирсан уу?

[ ] Тэрхүү эрх чөлөөгөө хэрхэн хадгалахаа та мэдэх үү?

[ ] Та нар "Энэ бол нигүүлслийн» цаг хугацаа" гэсний утгыг мэдэх үү?

[ ] Та тэнгэр ба газрыг бүтээсэн (үл үзэгдэгч) бие махан бие болж (үзэгдэх), үхэгсдээс амилж, Сатаны үхлийн хүчийг ялж Ариун Сүнсийг Түүний нэр болох Есүс Христийн нэртэй хүүхдүүд рүү илгээсэн ҮГийг мэдэх үү?

## **47.2 Түүний хүүхдүүдэд өгсөн амлалтууд**

### **47.2.1 Түүний хүүхэд болох**

<sup>3</sup>Бидний Эзэн Есүс Христийн Эцэг ба Бурхан магтагдах болтугай. Тэрээр Христ дотор тэнгэрлэг газар дахь алив сүнслэг ерөөлөөр биднийг ерөөсөн. <sup>4</sup>Түүний өмнө биднийг ариун бөгөөд гэм зэмгүй байлгахын тулд Бурхан ертөнцийн сууриас урьд биднийг Түүний дотор сонгосончлон, хайраараа <sup>5</sup>Тэр Өөрийн хүслийн сайн тааллын дагуу, биднийг Есүс Христээр Өөрийнхөө хөвгүүд болгон үрчлэн авахаар урьдаас тогтоожээ. <sup>6</sup>Энэ нь хайрлагдсан Түүний дотор бидэнд соёрхсон Түүний нигүүлслийн алдрыг магтуулахын тулд болой. <sup>7</sup>Түүний нигүүлслийн баялгийн

дагуу Түүний дотор цусаар нь золилт, гэм нүглийн маань төлөөх уучлал бидэнд байдаг.<sup>8</sup>Тэр бидэнд бүх мэргэн ухаан болон гүнзгий мэдлэг дотор тэрхүү нигүүлслээ бялхаажээ.<sup>9</sup>Тэр Түүний дотор зорилго тавьж, Өөрийнхөө сайн тааллын дагуу хүслийнхээ нууцыг бидэнд мэдүүлэв.<sup>10</sup>Энэ нь цагийн дүүрнийг гүйцэлдүүлэхийн тулд тэнгэр дэх юмс болон газар дээрх бүх юмсыг Христ дотор нэгтгэх зорилго байжээ. (Эфес 1:3-10 АБ 2004)

<sup>3</sup>Өөрийнхөө алдар ба давуу чанараар биднийг дуудсан Түүний жинхэнэ мэдлэгээр дамжуулан Түүний бурханлаг хүч бидэнд амь болоод сүсэглэлд хамаатай бүхнийг соёрхсон.<sup>4</sup>Эдгээрээр дамжуулан Тэр бидэнд үнэтэй бөгөөд гайхамшигт амлалтуудаа соёрхсон. Ингэснээр та нар энэ дэлхийд тачаалаар байх ялзралаас ангижирснаар бурханлаг мөн чанарын хуваалцагч болох юм. (2 Петр1:3-4 АБ 2004)

<sup>32</sup>Тэр Өөрийн Хүүгээ үл өршөөж, харин Түүнийг бид бүхний төлөө тушаасан юм. Тэгвэл Тэр яаж бүх юмыг Түүний хамт бидэнд сул өгөхгүй байх билээ? (Ром 8:32 АБ 2004)

<sup>23</sup>Есүс түүнд-“Хэрэв Та чаддаг бол” гэв үү? Итгэлтэй хүнд бүх юм боломжтой гэхэд( Марк 9:23 АБ 2004)

[ ] Тэр Өөрийн Есүс Христ нэрээр танд юу өгснийг та мэдэх үү ?

[ ] Түүний амлалтуудаас олж авсан зүйлээ болон тэдгээрийг хэрхэн олж авсанаа та дүрслэн хэлж чадах уу?

#### 47.2.2 Зөвтгөгдсөн, Зөвт нэгэн

##### Итгэлээр

<sup>1</sup>Тиймээс итгэлээр зөвтгөгдсөн бид бидний Эзэн Есүс Христээр дамжуулан Бурхантай эвлэрсэн билээ.<sup>2</sup>Мөн дотор нь зогсдог энэхүү нигүүлсэл уруу бид Түүгээр дамжуулан итгэлээр орох боломжтой болсон бөгөөд бид Бурханы алдрын найдварт баярладаг.<sup>3</sup>Түүгээр ч барахгүй, мөн зовлонтойдоо баярладаг. Учир нь зовлон зүдгүүр нь тэвчээрийг,<sup>4</sup>тэвчээр нь туршлагатай байхыг, туршлагатай байх нь найдварыг төрүүлдэг.<sup>5</sup>Найдвар нь урам хугалдаггүй.

Учир нь бидэнд өгөгдсөн Ариун Сүнсээр дамжуулан Бурханы хайр бидний зүрхэнд цутгагдсан байдаг.<sup>6</sup>Биднийг сул дорой байх үед, Христ тогтоосон цагт бурханлаг бус хүмүүсийн өмнөөс үхсэн билээ.<sup>7</sup>Зөвт хүний төлөө хэн нэгэн хүн бараг үхэхгүй. Харин сайн хүний төлөө бол хэн нэгэн хүн үхэхээр зүрхэлж магадгүй юм.<sup>8</sup>Гэвч биднийг нүгэлтнүүд байхад л Христ бидний төлөө үхсэн. Үүгээрээ Бурхан биднийг хайрлах хайраа харуулсан юм.<sup>9</sup>Тиймд эдүгээ Түүний цусаар зөвтгөгдсөн бид тэр тусмаа Түүгээр дамжуулан уур хилэнгээс ч аврагдах болно.<sup>10</sup>Учир нь хэрэв бид дайснууд байхдаа Хүүгийнх нь үхлээр Бурхантай эвлэрүүлэгдсэн юм бол, тэр тусмаа бид Түүний амиар аврагдах болно.<sup>11</sup>Зөвхөн үүнд ч биш, мөн Бурханы дотор бидний Эзэн Есүс Христээр дамжуулан баярлан хөөрдөг. Түүгээр бид эдүгээ эвлэрлийг авав. (Ром 5:1-11 АБ 2004)

[ ] Хэрхэн зөвтгөгдсөнөө та мэдэх үү?

[ ] Түүний хүүхдүүдийн хувьд дэлхий дээрх зовлон нь хэрхэн ерөөл рүү чиглүүлдэгийг та мэдэх үү?

[ ] Христ таныг зөвт байхад бус харин нүгэлтэн байхад үхсэнийг та мэдэх үү?

[ ] Өөрийн хүүхдүүдэд Бурханы өгсөн амлалтууд нь бодит бөгөөд үнэн гэдэгт та итгэдэг үү?

[ ] Бурханы хүүхдүүдэд Есүс Христ юу гэж амласныг та мэдэх үү?

### 47.2.3 Итгэлээр зөвтгөгдсөн Абрахам

<sup>1</sup>Тиймд махан биеэрээ бидний өвөг болсон Абрахам юуг олсон гэж бид хэлэх вэ? <sup>2</sup>Хэрэв Абрахам үйлсээрээ зөвтгөгдсөн бол тэр сайрхах юмтай. Гэхдээ Бурханы өмнө биш. <sup>3</sup>Сударт юу гэж байна вэ? “Абрахам Бурханд итгэсэн. Энэ нь түүнийг зөвд тооцуулсан байна” гэдэг. <sup>4</sup>Ажил хийдэг хүний хувьд цалин нь өглөг бус, харин төлбөр гэж тооцогддог. <sup>5</sup>Харин ажил хийдэггүй боловч, бурханлаг бус хүнийг зөвтгөдөг Түүнд итгэдэг хүний хувьд итгэл нь зөвд тооцогддог. <sup>6</sup>Түүнчлэн Давид бас үйлсгүйгээр Бурханд зөв хэмээн тооцогдсон хүний ивээгдсэнийг ийнхүү хэлжээ.

<sup>7</sup>“Хууль бус явдал нь уучлагдаж, Нүглүүд нь далдлагдсан хүмүүс ерөөлтэй. <sup>8</sup>Эзэн нүглийг нь огт үл тооцох тэр хүн ерөөлтэй” <sup>9</sup>Тэгвэл энэ ерөөл нь хөвч хөндүүлсэн хүмүүст хамаатай юу? Эсвэл хөвч хөндүүлээгүй хүмүүст бас хамаатай юм уу? Учир нь бид “Итгэл нь Абрахамыг зөвд тооцуулсан” гэж ярьдаг. <sup>10</sup>Тийм бол энэ нь яаж тооцуулсан юм бэ? Хөвч хөндүүлсэн байхдаа юм уу, эсвэл хөвч хөндүүлээгүй байхдаа юм уу? Хөвч хөндүүлсэн байхдаа биш, хөвч хөндүүлээгүй байхдаа юм. <sup>11</sup>Абрахам хөвч хөндүүлээгүй үедээ итгэлийн зөвийн тамгаар хөвч хөндөх ёслолын тэмдгийг хүлээн авчээ. Тэр хөвч хөндүүлэлгүй итгэдэг бүх хүний эцэг нь болж, тэднийг зөвд тооцуулахын тулд ингэжээ. <sup>12</sup>Мөн хөвч хөндүүлээд зогсохгүй, бас хөвч хөндүүлээгүй байхад нь бидний эцэг Абрахамд байсан итгэлийн мөрөөр мөшгөгч хүмүүст хөвч хөндөлтийн эцэг болов. <sup>13</sup>Учир нь ертөнцийн өв залгамжлагч байх болно хэмээн Абрахамд болон түүний үр удамд өгөгдсөн амлалт нь Хуулиар бус, харин итгэлийн зөвт байдлаар байсан аж. <sup>14</sup>Учир нь хэрэв Хуулиар байгсад нь өв залгамжлагчид юм бол, итгэл нь хоосон болгогдсон бөгөөд амлалт устгагдсан юм. <sup>15</sup>Учир нь Хууль уур хилэнг авчирдаг. Харин хаана хууль байхгүй байна, тэнд бас зөрчил гэж байхгүй. <sup>16</sup>Тиймээс нигүүлслийн дагуу байхын тулд тэр амлалт нь итгэлээр ирдэг. Ингэснээр тэрхүү амлалт нь бүх үр удамд, зөвхөн Хуулийн үр удамд төдийгүй, мөн Абрахамын итгэлийн үр удамд ч баталгаатай байх юм. Абрахам бол <sup>17</sup>(Энэ нь “Би чамайг олон үндэстний эцэг болгосон” гэж бичигдсэнчлэн ажээ) үхэгсдэд амь өгөгч, байхгүйг байгаагаар дуудагч, өөрийн итгэсэн Бурханы өмнө бид бүгдийн эцэг юм. <sup>18</sup>“Чиний үр удам ийм болно” гэж урьд нь айлдсан ёсоор тийнхүү олон үндэстний эцэг болохын тулд тэр найдах аргагүй үед найдан итгэсэн. <sup>19</sup>Тэр зуугаад насалсан тул биеийнхээ бараг үхсэнийг болон Сарагийнх нь умай үхмэл болсныг мэдсэн хэдий ч итгэлээр дорой болсонгүй. <sup>20</sup>Харин Бурханы амлалтын талаар тэр үл итгэн тээнэгэлзэлгүй, харин ч итгэлээр хүчирхэгжихдээ Бурханд алдрыг нь өргөн, <sup>21</sup>Бурхан амласнаа биелүүлэх чадвартай гэдэгт бүрэн итгэлтэй байлаа. <sup>22</sup>Тиймээс энэ нь түүнийг зөвт байдалд тооцуулсан ажээ. <sup>23</sup>“Тэр зөвт байдалд тооцогдсон” гэж бичигдсэн нь зөвхөн түүний төлөө бус, <sup>24</sup>бидний Эзэн Есүсийг үхэгсдээс амилуулсан Түүнд итгэж, зөвт байдалд тооцогдох мөн бидний төлөө билээ. <sup>25</sup>Есүс бидний нүгэл хилэнцээс болж тушаагдсан бөгөөд бидний зөвтгөлийн төлөө амилуулагдсан юм.( Ром 4:1-25 АБ 2004)

<sup>63</sup>Сүнс бол амь өгдөг, мах бол ашиггүй юм. Миний та нарт хэлсэн үгс бол сүнс ба амь билээ. ( Иохан 6:63 АБ 2004)

[ ] Хүмүүс яагаад Бурханы үгийг үнэгүйдүүлдэгийг та мэдэх үү?

[ ] Та Христэд итгэх итгэлээ сулруулаагүйгээ баталж чадах уу?

[ ] Та зөвт байдлынхаа төлөө болон авралын төлөө ажиллаж байна уу?

[ ] Бурханы хүүхдүүдэд Христ дотор өв залгамжлал байдаг гэдгийг та мэдэх үү?

[ ] Үг нь таны зүрх сэтгэлд (мөнхийн) ярих боловч сонсох боломжийг таны толгой (түр зуурын) олгохгүй байгааг та мэдэх үү?

[ ] Та үүнийг хэрхэн даван туулахаа мэддэг үү?

#### 47.2.4 Бурханы гэр бүл

<sup>31</sup>Есүсийн эх болон дүү нар нь ирээд гадаа зогсож, Түүнийг дуудуулахаар хүн оруулав. <sup>32</sup>Есүсийг олон хүн тойрон сууж байлаа. Тэд Түүнд -Хараач. Ээж болон дүү нар тань Таныг хүлээгээд гадаа байж байна гэхэд, <sup>33</sup>Тэр тэдэнд хариулан -Хэн Миний ээж, [Миний] дүү нар юм бэ? гээд, <sup>34</sup>Өөрийг нь хүрээлэн суугчдыг хараад,-Миний ээж болон Миний дүү нарыг харагтун. <sup>35</sup>[Яагаад гэвэл] Бурханы хүслийг биелүүлэгч хэн боловч Миний ээж болон дүү нар минь юм гэж айлдав.( Марк 3:31-35 АБ 2004 )

<sup>11</sup>Харин Мариа булшны гадаа зогсоод уйлж байлаа. Тэр уйлсан чигээрээ булш уруу тонгойн харахад, <sup>12</sup>цагаан хувцастай хоёр тэнгэр элч Есүсийн цогцсыг тавьсан газарт нэг нь толгойн тэнд, нөгөө нь хөлөн талд нь сууж байв. <sup>13</sup>Тэд түүнд -Эмэгтэй, чи юунд уйлна вэ? гэсэнд тэр-Тэд Эзэнийг минь авчихсан байна. Тэд Түүнийг хаана тавьсныг би мэдэхгүй гэв.

<sup>14</sup>Тэр ингэж хэлээд эргэхдээ Есүсийн зогсож байхыг харсан боловч тэр нь Есүс байсныг таньсангүй. <sup>15</sup>Есүс түүнд - Эмэгтэй, чи юунд уйлна вэ? Чи хэнийг хайна вэ? гэж асуув.

Түүнийг цэцэрлэгч байна гэж бодоод тэр Түүнд -Эзэнтэн, хэрэв та Түүнийг авсан бол хаана тавьснаа надад хэлнэ үү? Би Түүнийг авах гэсэн юм гэв.<sup>16</sup>Гэтэл Есүс -Мариа гэлээ. Мариа эргэнгүүтээ Түүнд еврейгээр -Рабуни! (Багш гэсэн утгатай) гэжээ.

<sup>17</sup>Есүс -Би дээшээ Эцэгтээ хараахан очоогүй байгаа тул Надад гар бүү хүр. Харин Миний ах дүү нар уруу очиж, тэдэнд “Би Миний Эцэг ба та нарын Эцэгт, Миний Бурхан ба та нарын Бурханд очно” гэдгийг хэл гэлээ.<sup>18</sup>Магдалын Мариа ирж, шавь нарт-Би Эзэнийг харлаа гээд Есүсийн өөрт нь айлдсаныг тэдэнд хэлэв. (Иохан 20:11-18 АБ 2004 )

[ ] Та Бурханы хүсэл юу болохыг мэдэх үү? Бурханы хүслийг та биелүүлж байна уу?

[ ] Та Христ Есүсийг тэрхүү булшнаас эсвэл загалмай дээрээс хайж байна уу?

Та Христийн үхлийн төлөө уйлдаг уу ?

[ ] Амилсан Христ таньтай уулзахаар ирж тэрхүү эргэлзэгчийн зүрх сэтгэлийг нь тогшиж байгааг та мэдэх үү ?

[ ] Христийн амилсны дараа таны өөрийн нөхцөл байдалд өөрчлөлт гарсныг та мэдэх үү ?

#### **47.2.5 Дэлхийн хувьд харь хүмүүс**

<sup>1</sup>Есүс Христийн элч Петр би Понт, Галат, Каппадок, Ази болон Битун нутгуудаар тархсан, түр суурьшигч нарт илгээв. <sup>2</sup>Та нар бол Бурханы урьдаас мэдэх мэдлэгийн дагуу, Сүнсний ариусгалаар Есүс Христэд дуулгавартай байхын тулд болон Түүний цусаар цацуулахын тулд сонгогдсон билээ. Нигүүлсэл ба амар тайван нь та нарт улам арвин болох болтугай. (1 Петр 1:1-2 АБ 2004 )

<sup>9</sup>Иаков Фараонд -Би газар орон хэрэн явсаар зуун гучин жил болж байна. Би тийм ч урт наслаагүй, өвөг дээдсийнхээ нутаг газар сэлгэн амьдарсан он жилүүдэд хүрээгүй боловч хүнд бэрхийг тууллаа гэв. (Эхлэл 47:9 АБ 2004 )



<sup>5</sup>Хүч нь Таны дотор, Зүрхэнд нь Сион уруу хөтлөх замууд байх хүн юутай ерөөлтэй вэ! ( Дуулал 84:5 АБ 2004 )

<sup>6</sup>Нэгэн дуу “Дуудагтун” гэсэнд би “Би юуг дуудах вэ?” гэж хариулав. Бүх махан бие нь өвс бөгөөд түүний бүх сүр жавхлан нь талын цэцэг мэт юм. <sup>7</sup>ЭЗЭНий амьсгал дээрээс нь үлээвэл өвс хатаж, цэцэг гандана. Хүмүүс үнэхээр өвс юм. <sup>8</sup>Өвс хатаж, цэцэг гандана. Харин бидний Бурханы үг мөнхөд тогтоно. ( Исаиа 40:6-8 АБ 2004 )

[ ] Элч Петрийн энд дүрсэлсэн хүмүүсийн нэг та мөн үү?

[ ] Та амьдралдаа дуртай байж тамын биш тэнгэрийн хаанчлалын гэрчлэл цуглуулахдаа дуртай байна уу ?

### 47.3 ХУВЬ ЗАЯА

#### 47.3.1 Зөв шударга боол

<sup>15</sup>Тэгвэл яах вэ? Бид хуулийн дор бус, харин нигүүлслийн дор байдаг учраас нүгэл үйлдэх үү? Бүү ийм байх болтугай! <sup>16</sup>Та нар өөрсдийгөө дуулгавартай байхаар боол болгон хэн нэгэнд өгөхдөө, үхэлд хүргэх нүглийн ч бай, эсвэл зөвт байдалд хүргэх дуулгавартай байдлын ч бай, дагах нэгнийхээ боол нь болдгоо мэдэхгүй гэж үү? <sup>17</sup>Харин Бурханд талархал нь байг. Учир нь та нар нүглийн боолууд байсан боловч та нар өөрсдөд чинь өгөгдсөн уг сургаалын хэв маягт зүрхнээсээ дуулгавартай болж, <sup>18</sup>нүглээс чөлөөлөгдөн зөвт байдлын боолууд болсон. <sup>19</sup>Та нарын махан бие сул дорой тул би хүний ёсоор хэлье. Та нар өөрсдийн эрхтнүүдийг ёс бус явдалд хүргэх цэвэр бус, ёс бус байдалд боол болгон өргөснийхөө адил түүнчлэн одоо өөрсдийн эрхтнүүдээ ариусгалд хүргэх зөвт байдалд боол болгон өргө. <sup>20</sup>Учир нь та нар нүглийн боол байхдаа зөвт байдлаас чөлөөтэй байжээ. <sup>21</sup>Тэгэхэд та нар одоо ичиж байгаа зүйлсээс ямар үр жимс авсан бэ? Учир нь тэдгээр зүйлсийн төгсгөл бол үхэл болой. <sup>22</sup>Харин одоо нүглээс чөлөөлөгдсөн бөгөөд Бурханд боолчлогдсон та нарт ариусгалд хүрэх үр жимс авдаг. Төгсгөл нь мөнх амь болой. <sup>23</sup>Учир нь нүглийн хөлс бол үхэл, харин Бурханы бэлэг бол бидний Эзэн Христ Есүс доторх мөнх амь мөн. ( Ром 6:15-23 АБ 2004 )

[ ] Та зөв шударга үйл хийхийг хүсэж байна уу?

[ ] Нүгэлтэй хамаг чадлаараа та тэмцдэг үү?

[ ] Нүглийн урхийг хэрхэн даван туулахаа та мэддэг үү?

[ ] Цалин хөлс ба бэлэгний ялгааг та мэдэх үү?

#### 47.3.4 Арван хууль

• Бурхан эдгээр бүх үгийг хэлсэн:

<sup>2</sup>-Би бол чамайг боолчлолын гэрээс, Египетийн нутгаас гаргасан чиний Бурхан ЭЗЭН байна.

1 <sup>3</sup>Чи Надаас өөр бурхадтай байж болохгүй.

2 Чи өөртөө зориулан шүтээн эсвэл дээр тэнгэр дэх, доор газар дахь, газрын доор усан доторх юмны ямар нэг дүрсийг бүү хий. <sup>5</sup>Чи тэдэнд мөргөж, тэдэнд үйлчилж болохгүй. Учир нь чиний Бурхан ЭЗЭН Би бол хартай Бурхан бөгөөд Намайг үзэн ядагчдын гурав, дөрөв дэх үеийн хүүхдүүдэд нь хүртэл эцгүүдийнх нь нүглийн шийтгэлийг буулгадаг. <sup>6</sup>Харин Намайг хайрлаж, Миний тушаалыг сахигчдад мянган үед нь хүртэл хайр энэрлээ үзүүлдэг.

3 <sup>7</sup>Чи өөрийн Бурхан ЭЗЭНий нэрийг дэмий бүү дурд. Учир нь ЭЗЭН Өөрийнх нь нэрийг дэмий дурдагчийг шийтгэлгүй орхихгүй.

4 <sup>8</sup>Амралтын өдрийг ариунаар сахихын тулд санагтун. <sup>9</sup>Зургаан өдөр чи хөдөлмөрлөж, бүх ажлаа хий. <sup>10</sup>Харин долоо дахь өдөр бол чиний Бурхан ЭЗЭНий амралт тул чи болон чиний хүү, чиний охин, чиний зарц, шивэгчин, чиний мал, танайд байгаа зочин ямар ч ажил хийж болохгүй. <sup>11</sup>Учир нь ЭЗЭН тэнгэр, газар, далай болон тэдгээрийн дотор байгч бүгдийг зургаан өдөрт бүтээж, долоо дахь өдөрт амарсан. Тиймээс ЭЗЭН Амралтын өдрийг ерөөн, тэр өдрийг ариун болгосон юм.

5 <sup>12</sup>Эцэг эхээ хүндэл. Тэгвэл чиний Бурхан ЭЗЭНий чамд өгсөн газар дээр чи урт наслах болно.

6 <sup>13</sup>Чи хүн бүү ал.

7 <sup>14</sup>Чи бүү завхайр.

8 <sup>15</sup>Чи бүү хулгайл.

9 <sup>16</sup>Чи хөршийнхөө эсрэг худал бүү гэрчил.

10 <sup>17</sup>Чи хөршийнхөө гэр оронд бүү шунахайр. Чи хөршийнхөө эхнэр болон түүний зарц, түүний шивэгчин, түүний үхэр, түүний илжиг, хөршийнхөө юунд ч бүү шунахайр гэв. <sup>18</sup>Бүх ард түмэн тэнгэрийн дуу, аянгын гялбаа, бүрэн дуу, утаа багширсан уулыг харангуутаа айн дагжиж, холдон зогсоод,

[ ] Бурхан ямар учраас эдгээр хууль өгснийг та мэдэх үү?

[ ] Хууль бүрийн хувьд "зүүн эсвэл баруун тийш" гэдэг нь юу гэсэн үг вэ?

[ ] Есүс эдгээр хуулийг хэрхэн тайлбарласныг та мэдэх үү?

#### 47.2.5 Ерөөл

- Есүс хэлэхдээ:

<sup>3</sup>Сүнсэн дотроо ядуу хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм. <sup>4</sup>Гашуудаж буй хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд тайвшрал авах болно.

<sup>5</sup>Дөлгөөн хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд дэлхийг өвлөн авах болно.

<sup>6</sup>Зөвт байдлын төлөө өлсөж цангагч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд хангалуун болох болно. <sup>7</sup>Энэрэнгүй хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд өршөөл энэрлийг хүртэх болно.

<sup>8</sup>Зүрхэн дотроо цэвэр ариун байгч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд Бурханыг харах болно.

<sup>9</sup>Амар тайвныг тогтоогч хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэд Бурханы хөвгүүд гэж нэрлэгдэх болно.

<sup>10</sup>Зөвт байдлын төлөө хавчигдсан хүмүүс ерөөлтэй ээ! Учир нь тэнгэрийн хаанчлал бол тэднийх юм. <sup>11</sup>Надаас болж та нарыг

хүмүүс доромжилж, хавчиж, хуурамчаар та нарын эсрэг зүсэн бүрийн хорон мууг ярихад та нар ерөөлтэй ээ!

<sup>12</sup>Тэнгэр дэх шагнал тань агуу учир баярлацгаа, мөн баяр хөөртэй байцгаа. Учир нь та нараас өмнө байсан эш үзүүлэгчдийг тэд ийнхүү хавчсан юм. (Матай 5:3-12 АБ 2004)

«Сүнсэн дотор ядуу» байна гэдэг ямар утгатай вэ? Хүмүүст ирэх хувь заяаны улмаас зүрх тань бусдын төлөө гашуудаж байна уу? Даруу хүн юу хийдгийг та мэдэх үү?

<sup>5</sup>Яг энэхүү шалтгааны улмаас та нар бүхий л хичээл зүтгэлээр, итгэл дээрээ сайн давуу байдлыг, сайн давуу байдал дээрээ мэдлэгийг, <sup>6</sup>мэдлэг дээрээ өөрийгөө захирах байдлыг, өөрийгөө захирах байдал дээрээ тэвчээрийг, тэвчээр дээрээ сүсэглэлийг, <sup>7</sup>сүсэглэл дээрээ ах дүүсэг энэрлийг, ах дүүсэг энэрэл дээрээ хайрыг хамтатга. <sup>8</sup>Хэрэв та нарт эдгээр чанарууд байгаа бөгөөд улмаар нэмэгдсээр байвал, эдгээр нь бидний Эзэн Есүс Христийг мэдэхэд та нарыг үр ашиггүй, үр жимсгүй байлгахгүй. <sup>9</sup>Эдгээр чанаруудаар дутагддаг хүн бол урьдын нүглүүдээсээ цэвэршсэнээ мартсан, сохор, эсвэл богино бодолтой нэгэн юм. <sup>10</sup>Тиймээс ах дүү нар аа, Түүний та нарыг дуудан, сонгосныг бататгахын тулд бүр ч илүү хичээнгүй бай. Учир нь та нар эдгээрийг үйлдэж л байвал хэзээ ч бүдрэхгүй. <sup>11</sup>Ингэснээр бидний Эзэн бөгөөд Аврагч Есүс Христийн мөнх хаанчлал уруу хангалттай орох болно. (2 Петр 1:5-11 АБ 2004)

[ ] Таны амьдралд эдгээр шинж чанар байдаг уу?

[ ] Эдгээрийг олж авахад саад болдог зүйлс дийлж, зайлсхийхээ та мэддэг үү?

[ ] Таны итгэл ба үнэмшил ойр зуурынх байна уу?

[ ] Тэнгэрийн хаанчлал өөр төрлийн шалгууртай гэдгийг та мэдэх үү?

#### **47.4 ЗОРИЛГО, ЧИГЛЭЛ**

Бурханы алдрын төлөө

Сайн мэдээний төлөө.

Шинэ тэнгэр, Шинэ газар руу холбогдсон.

#### 47.4.1 Хаанчлалын иргэн

<sup>9</sup>Тэр ийнхүү айлдсаны дараа тэднийг харж байхад нь дээш өргөгдөж үүлэнд орж тэдэнд харагдахгүй болов. <sup>10</sup>Түүний одохыг харж тэнгэр өөд гөлрөн байсан тэдний хажууд цагаан өмсгөлтэй хоёр хүн зогсоод, <sup>11</sup>хэлсэн нь -Галилын эрчүүд ээ, юунд та нар тэнгэр ширтэн зогсоно вэ? Та нараас өргөгдөн тэнгэрт аваачигдсан энэ Есүс нь та нарын Түүнийг тэнгэр өөд явсныг нь харсан лугаа адил тийн буцаж ирнэ гэв. (Үйлс 1:9-10 АБ 2004)

<sup>13</sup>Би шөнийн үзэгдлийг харсаар байсан бөгөөд, Харагтун, Хүний Хүү шиг Нэгэн тэнгэрийн үүлсийг хөлөглөн ирж, Тэрээр Эртний Нэгэнд очоод, Түүнд бараалхав. <sup>14</sup>Түүнд эрх мэдэл, сүр жавхлан ба хаанчлал өгөгдөж, Бүх ард түмэн, үндэстэн, бүх хэлтэн Түүнд үйлчлэв. Түүний ноёрхол үүрдийн ноёрхол бөгөөд өнгөрөн одохгүй. (Даниел 7:13-14 АБ 2004)

[ ] Та нар Түүний "Миний эцэг, Таны Эцэг, миний Бурхан, Таны Бурхан" гэхийг сонссон уу?

[ ] Түүний хүүхдүүдийн хувьд нэг ч болтугай сүнсийг аварна гэдэг нь Түүний дахин ирэлтээс өмнө чухал ажил юм гэдэгт та итгэдэг үү?

[ ] Та Түүний мөнхийн хаанчлалын иргэн мөн үү?

#### 47.4.2 Шинэ тэнгэр, Шинэ газар, даяанчлал

<sup>1</sup>Би шинэ тэнгэр, шинэ газрыг харлаа. Учир нь анхны тэнгэр, анхны газар нь өнгөрөн одож, тэнгис байхгүй болов. <sup>2</sup>Ариун хот, шинэ Иерусалим нь нөхөртөө очихоор гоёсон сүйт бүсгүй мэт бэлтгэгдэн Бурханаас гарч, тэнгэрээс буун ирэхийг би харлаа. <sup>3</sup>Сэнтийнээс чанга дуу гарахыг би сонсов. -Харагтун, Бурханы асар хүмүүсийн дунд байна. Тэр тэдний дунд нутаглах болно. Тэд Түүний ард түмэн болж, Бурхан

Өөрөө тэдний дунд байж [тэдний Бурхан нь болно].<sup>4</sup>Тэр тэдний нүднээс нулимс бүрийг нь арчина. Тэнд цаашид үхэл байхгүй болно. Тэнд цаашид гашуудах, уйлах, өвдөх гэж үгүй болно. Анхны юмс өнгөрөн одлоо.<sup>5</sup>Сэнтийд Залрагч - Харагтун, Би бүх юмсыг шинэ болгож байна гээд -Бичигтүн, эдгээр үгс итгэмжит бөгөөд үнэн гэв.<sup>6</sup>Тэр надад -Биеллээ. Би бол Альфа ба Омега, Эхлэл ба Төгсгөл. Цангасан нэгэнд Би амийн усны булгаас үнэгүй өгнө.<sup>7</sup>Ялагч нь эдгээр зүйлийг өвлөх бөгөөд Би түүний Бурхан болж, тэр Миний хүү болно.<sup>8</sup>Харин хулчгар, итгэлгүй, жигшүүрт, алуурчид, завхай хүмүүс, мэргэ төлөгчид, шүтээнд мөргөгчид болон бүх худалч хүмүүсийн хувьд, тэдэнд оногдох хувь нь хоёр дахь үхэл буюу хүхэр, галаар шатаж буй нуурт байна гэв. (Илчлэлт 21:1-8 АБ 2004)

<sup>9</sup>Сүүлчийн долоон гамшгаар дүүрэн долоон аягатай долоон тэнгэр элчийн нэг нь ирээд надтай ярилцан -Нааш ир. Би чамд Хурганы эхнэр болох сүйт бүсгүйг үзүүлэе гэв.<sup>10</sup>Тэр намайг сүрлэг өндөр уулан дээр Сүнс дотор аваачаад Бурханаас гарч, тэнгэрээс буун ирж буй ариун хот Иерусалимыг үзүүллээ.<sup>11</sup>Түүнд Бурханы алдар нь байлаа. Гялбаа нь үнэт чулуу мэт бөгөөд талст шиг тунгалаг хас чулуу мэт байв.<sup>12</sup>Тэр нь асар том өндөр хэрэмтэй бөгөөд арван хоёр хаалгатай байлаа. Хаалганууд дээр нь арван хоёр тэнгэр элч байлаа. Тэдгээрийн дээр Израилийн хөвгүүдийн арван хоёр овгийн нэрс бичигдсэн байв.<sup>13</sup>Зүүн талд нь гурван хаалга, хойд талд нь гурван хаалга, өмнө талд нь гурван хаалга, баруун талд нь гурван хаалга байх аж.<sup>14</sup>Хотын хэрэм нь арван хоёр суурьтай агаад тэдгээрийн дээр Хурганы арван хоёр элчийн арван хоёр нэрс байлаа.<sup>15</sup>Надтай ярьсан тэнгэр элчид хот болон хаалгануудыг, мөн хэрмийг нь хэмжих алтан шугам байв.<sup>16</sup>Хот нь дөрвөлжин бөгөөд урт нь өргөнтэйгөө адил аж. Тэнгэр элч хотыг шугамаараа хэмжихэд урт, өргөн, өндөр нь адилхан арван хоёр мянган стадиа байлаа.<sup>17</sup>Тэр хотын хэрмийг хэмжихэд, хүний хэмжээс ба мөн тэнгэр элчийн хэмжээсээр зуун дөчин дөрвөн пехус болов.<sup>18</sup>Хэрмийг хас чулуугаар хийсэн бөгөөд хот нь тунгалаг шил мэт шижир алт ажээ.<sup>19</sup>Хотын хэрмийн сууриуд

нь төрөл бүрийн эрдэнийн чулуугаар чимэглэгджээ. Эхний суурь нь хас, хоёр дахь нь индранил, гурав дахь нь гартаам, дөрөв дэх нь маргад эрдэнэ,<sup>20</sup> тав дахь нь мамагартаам, зургаа дахь нь нал, долоо дахь нь хашиг, найм дахь нь биндэрьяа, ес дэх нь молор, арав дахь нь мана, арван нэг дэх нь оюу, арван хоёр дахь нь ягаан болор байв.<sup>21</sup> Арван хоёр хаалга нь арван хоёр сувд ажээ. Хаалга нэг бүр нь нэгэн цул сувд байсан бөгөөд хотын гудамж нь тунгалаг шил мэт шижир алт байв. (Илчлэлт 21:9-21 АБ 2004)

<sup>22</sup>Би хотод ямар ч сүм харсангүй. Учир нь Төгс хүчит Эзэн Бурхан ба Хурга бол тэндхийн сүм юм.<sup>23</sup> Хотод дээрээс нь гэрэлтүүлэх нар, сар хэрэггүй ажээ. Учир нь Бурханы цог жавхлан түүнийг гэрэлтүүлсэн бөгөөд дэнлүү нь Хурга байлаа.<sup>24</sup> Үндэстнүүд тэр гэрлээр нь алхацгааж, газрын хаад тийшээ алдраа авчирна.<sup>25</sup> Хотын хаалганууд өдөр хэзээ ч хаагдахгүй. Учир нь тэнд шөнө гэж байхгүй.<sup>26</sup> Тэд үндэстнүүдийн алдар, хүндлэлийг тийшээ авч ирнэ.<sup>27</sup> Ямар ч бузар юм болон жигшүүрт зүйл үйлддэг болон худал ярьдаг хэн ч хэзээ ч тийшээ орохгүй. Харин зөвхөн Хурганы амийн номд нэрс нь бичигдсэн хүмүүс л орох ажгуу. (Илчлэлт 21:22-27 АБ 2004)

[ ] Бурхан хэрхэн Өөрийн хүмүүстэй хамт оршиж байгааг та мэдэх үү? Амьд Бурхантай өнөөдөр хэрхэн уулзахаа мэдэх үү?

[ ] Бүх зүйлийг түүний дотор та бид хоёрыг шинэ болгох төлөвлөгөөтэйг та мэдэх үү,

[ ] Амийн усыг үнэгүй өгдөг. Та амийн устай юу?

[ ] Та үүнийг хэрхэн олж авахаа мэдэх үү?

[ ] Та зовлон бэрхшээлийг даван туулахад бэлэн үү?

[ ] Та энэ шинэ Иерусалим хотыг харахыг хүсэж байна уу?

[ ] Та энэ шинэ хотод сүр жавхлан хүлээж бүх зүйлийг алдахыг хүсэж байна уу?

[ ] Таны нэр Хурганы номонд бичигдсэн үү?

[ ] Амийн номонд бичигдээгүй хүмүүсийн төлөө та гашуудаж, залбирч байна уу?